Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 7 дугаар хавсралт

*Төлөвлөгөөг хянасан:*
Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын дарга ...................... (Ж.Тамир)
*(албан тушаал)* *(гарын үсэг)*
*(огноо)*

*Тэмдэг* ......................

*Төлөвлөгөө тайлагнасан:*
Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын захирал ...................... (Ө.Лувсанренчин)
*(албан тушаал)* *(гарын үсэг)*
*(огноо)*
2023-12-13

*Тэмдэг*

## "ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР" ТӨААТҮГ-ЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот Түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Үйлчлүүлэгч байгууллага бүртэй байгуулсан гэрээний үүргийг бүрэн биелүүлж, харилцан үр ашигтайгаар урт хугацаанд хамтран ажиллах** | | | | | | | |
| 1. | **"Ажлын байрны хэвийн, таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх"** зорилтын хүрээнд: | 5,4 тэрбум төгрөг | Төрийн байгууллага, тэдгээрийн албан хаагчид ажил үүргээ хэвийн таатай орчинд гүйцэтгэх нөхцөлийг тогтмол бүрдүүлэн ажиллах. | Үйлчлүүлэгчдэд ISO 9001:2015 стандартын шаардлага хангасан үйлчилгээг тогтмол үзүүлэн ажилладаг. | ISO 9001:2015 стандартад нийцэх үйлчилгээг хэрэглэгчдэд үзүүлэхдээ тэдгээрийн сэтгэлд нийцсэн байхаар ажилласан байх. | Үйлчлүүлэгчид ажил үүргээ хэвийн таатай орчинд гүйцэтгэх нөхцөлийг хангах хүрээнд агаар сэлгэлт, гэрэлтүүлэг, ус, дулаан, цэвэрлэгээ үйлчилгээ зэрэг цөгц асуудалд тогтмол анхаарч, хяналт тавин ажилласнаар хэрэглэгчдээс гомдол гаргахгүй, сэтгэлд нийцсэн үйлчилгээг нь бүрэн үзүүлэн ажиллалаа.<br>Тус онд Засгийн газрын байруудад байрладаг төрийн байгууллагуудын байршил солигдон нүүдэллэх, олон өрөөнд их болон урсгал засвар хийсэн онцлог жил болсон.<br>Үзүүлж буй үйлчилгээний чанар, үр дүнг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэглэгч үйлчлүүлэгчдээр үнэлүүлэхэд сэтгэл ханамжийн түвшин 65,4 хувиар "хангалттай" түвшинд үнэлэгдсэн. | |
| 1.1 | Цэвэрлэгээ үйлчилгээний ажил гүйцэтгэх | 3,5 тэрбум төгрөг | ISO 9001:2015 стандартад нийцсэн цэвэрлэгээ үйлчилгээ үзүүлэх | Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 олон улсын стандартын шаардлага хангасан тул ISO 9001:2015 гэрчилгээ, тэмдэглэгээг хэрэглэх эрхийг 3 жилээр буюу 2021-2024 онд дахин үргэлжлүүлэн эзэмших эрх авсан. | Стандарт, хэмжил зүйн газраас жил бүр хийдэг төлөвлөгөөт шалгалт /ISO 9001:2015/-нд хангалттай үнэлгээ авч, үргэлжлүүлэн эзэмшсэн байна. Тухайн стандартад нийцүүлэн цэвэрлэгээ үйлчилгээний ажлыг эрхлэн гүйцэтгэж ажиллана. | Стандарт, хэмжил зүйн газраас 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хийсэн магадлан аудитын шалгалтаар том, жижиг, залруулаагүй байгаа үл тохирол илрээгүй бөгөөд ISO 9001:2015 гэрчилгээг үргэлжлүүлэн эзэмших эрх авсан.<br>Тус ажлыг олон улсын чанарын удирдлагын тогтолцоо (ISO 9001:2015)-нд нийцэх хэлбэрээр үзүүлэн ажиллав. | 100% |
| 1.2 | Эрүүл ахуйн хяналт, ариутгалын үйлчилгээ хийж ажиллах. | 3,2 сая төгрөг | Монгол Улсад бүртгэгдсэн, чанарын шаардлага хангасан бодисоор, технологийн горимийг хангасан ариутгал, халдваргүйтгэл хийх | 65015,2 м.кв талбайд халдваргүйтгэл, шавьжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийг хийж ажилладаг. | Бүх өрөө, тасалгаанд халдваргүйтгэл, ариутгал, шавьжийн устгал /65015,2 м.кв/ хийж эрүүл, цэвэр, аюулгүй орчин бүрдүүлсэн байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан "Жагсаалт батлах тухай" А/42, А/52, А/71 дугээр тушаалаар батлагдсан халдваргүйжүүлэх бодисоор харьяа байруудын бүх талбайд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг өдөр тутамд болон долоо хоног бүр хийхийн зэрэгцээ шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар эцсийн халдваргүйтгэл, ариутгал, халдваргүйжүүлэлтийн устгалыг 25,557.6 метр квадрат талбайд, хортон шавьж, мэрэгчгүйтгэлийн устгалыг 9,814.2 метр квадрат талбайд, хогц, мөөгөнцөрийн устгалыг 930 метр квадрат талбайд, нийт 36,301 метр квадрат талбайд мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэн ажиллав. Мөн сард нэгээс доошгүй удаа 68,368.16 метр квадрат талбайг жилийн турш өөрсдөө ариутган ажиллаж, шаардлагатай талбайд хортон шавьж устгалын бодисыг байрлуулан ажиллаж байна. Ингэснээр аливаа халдварт өвчнөөс үйлчлүүлэгчдийг урьдчилан сэргийлэх, ажлын байранд шавьж, мэрэгч амьтан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үүсэх, үүрлэх нөхцөлийг арилгаж, ажилтнууд эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. | |
| 1.3 | Цай визитийн үйлчилгээгээр үйлчлэх | 33,8 сая төгрөг | Эрүүл мэндэд тустай 43,628 аяга цай, 21,508 аяга кофе, 3,173 аяга аарц, чацаргана, ус зэрэг бүтээгдэхүүнээр үйлчилж, эрүүл аюулгүй байдлыг хангаж ажиллах | Стандартын дагуу зочид, үйлчлүүлэгчдэд 43,628 аяга цай, 21,508 аяга кофе, 3,173 аяга аарц, чацаргана, ус зэргээр тогтмол үйлчилдэг | Цайны үйлчилгээний NUG-S-006 стандартад нийцсэн үйлчилгээг хэрэглэгчдэд тогтмол хугацаанд хүргэн ажиллах. | Засгийн газрын II, III, IV, VIII, XII, XIII байрууд болон Соёлын яаманд цайны үйлчилгээг NUG-S-006 стандартын дагуу үзүүлж нийт 45,970 аяга цай, 9,527 аяга аарц, чацаргана, ус, 21209 аяга кофег шуурхай соёлч боловсон, эрүүл ахуйн шаардлага хангасан хэлбэрээр технологийн дагуу үзүүлэн ажиллав. | 100% |
| 1.4 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цэцэг, ногоон байгууламжийг арчлан хамгаалж, тарьж ургуулах. | 1,5 сая төгрөг | Ургуулж буй 3,145 ширхэг цэцэг, 10,764 метр квадрат талбайг зүлэгжүүлэх болон 80 цэцгийн мандал зэргийг байгуулсан, арчлан хамгаалсан эсэх; | Харьяа байруудад 3,145 ширхэг цэцэг арчилж, 10764 метр квадрат талбайд зүлэгжүүлж, 80 цэцгийн мандалд цэцэг тарьж ургуулдаг. | Гадна, дотор талын ногоон байгууламжийг арчлан ажилласнаар ашигтай, хүний эрүүл мэндэд тустай цэцгийн нэр төрөл, мод зэргийн тоо хэмжээ нэмэгдэж, орчны тохижилт сайжирсан байна. | Засгийн газрын харьяа байруудын өрөө тасалгаан дахь 3,145 ширхэг цэцгийг арчлан хамгаалж тохижилтыг сайжруулан ажиллав.<br>Гадна талбайн 89 ширхэг улиас мод, 12 ширхэг монос, бусад бут сөөгөнд шохойдолт хийж, тайрч засан, арчлан нөхөн сэргээв. Хаврын улиралд буюу 4, 5 дугаар сард гадна талын ногоон байгууламжийг цэвэрлэн, гадна талбайн 10,764 метр квадрат ногоон байгууламжийн талбайн хог ургамлыг устгаж, орчныг цэвэрлэн, өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор өвс ногоог тэгшлэн хэлбэржүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн шинээр 39 метр квадрат талбайд шинээр зүлэг тарьж, 493 метр квадрат талбайд нөхөн зүлэгжүүлэлт хийж, 109 ширхэг цэцгийн мандал зэргийг тус тус арчлан хамгаалж, ургуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100% |
| 1.5 | Коронавирус /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байх. | — сая төгрөг | Коронавирус /Ковид-19/ цар тахлын үед үйлчилгээний байгууллагад тавигдах шаардлага, дүрэм журмыг мөрдөн ажиллах; | Коронавирус /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үйлчилгээний байгууллагуудын мөрдөн ажиллах дэглэм, дүрэм журмыг мөрдөн ажиллаж | Коронавирус /Ковид-19/ цар тахлын үед үйлчилгээний байгууллагуудад тавигдах шаардлага, дүрэм журмыг мөрдөн, тогтмол шинэчлэн ажиллана. | - Коронавирус (Ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 01 дүгээр тогтоолыг тус тус чанд мөрдөн ажиллалаа. Мөн Улсын онцгой комиссын даргын гаргасан удаа дараагийн бүх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байна. | | шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллахын зэрэгцээ байгууллагын захирлын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/77 тоот тушаалаар батлагдсан "Коронавирус (Ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлж ажиллах түр журам, төлөвлөгөө"-г мөрдөн, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэгжүүлэн ажилласан.<br>Харин 2023 оны 03 дугаар сард гарсан Улсын онцгой комиссын шийдвэрээр коронавирус (Ковид-19) цар тахлын үед мөрдөх дэглэм журмыг өөрчлөлж, энгийн хэлбэрт шилжин ажиллах болсонтой холбоотойгоор дэглэм журмыг бууруулан ажиллах болсон. | |
| 1.6 | Нийтлэг гардаг зарим хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, зохистойгоор хаяж зөөвөрлөсөн байх | — сая төгрөг | Байруудад хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах хогийн савыг хийж байршуулан, зохистойгоор хаяж зөөвөрлөсөн байх | 2022 онд хоёр байранд хог ангилан ялгах сав байрлуулсан | Харьяа 4-өөс доошгүй байранд төмрийн хог хаягдлыг ангилж ялган, цуглуулах дадлыг хэвшүүлсэн байна;<br>Төмрийн хог хаягдлыг холбогдох дахин боловсруулах аж ахуй нэгжид нийлүүлэн ажиллах | Харьяа 14 байранд ангилан ялгах хогийн савыг өөрсдийн нөөц боломжийг ашиглан хийж байрлуулав.<br>Улмаар барилга /төмөр, мод, цонх/-ын хог хаягдлыг дахин боловсруулах цэгт тушааснаар 1,3 сая төгрөгийн нэмэлт орлого олохын зэрэгцээ хог хаягдлыг дахин боловсруулах ажилд ахиц дэвшил гарган ажилласан. | 100% |
| 1.7 | Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэн ажиллах | 4,7 сая төгрөг | Цэнэгтүй болсон галын хорыг тухай бүрт нь 100 хувь цэнэглэсэн эсэх;<br>"Гал түймэр, газар хөдлөлт, гамшиг ослын үед өөрийгөө болон бусдыг хэрхэн авран хамгаалах тухай" сэдвээр сургалт зохион байгуулсан эсэх; | Галын хорын даралтыг тогтмол шалгаж, даралтгүй болох үед нь тухай бүр дахин цэнэглүүлж ажилладаг.<br>Харьяа байруудын ажилчдад "Газар хөдлөлт, гамшиг ослын үед өөрийгөө болон бусдыг хэрхэн авран хамгаалах вэ?" сэдвээр бодитоор үзүүлэх сургалтыг Төрийн ордны онцгой байдлын албатай | Даралтгүй болсон галын хорыг тухай бүрт нь цэнэглэж ажиллана.<br>Орчин үеийн дэвшилтэт хэлбэрийн гал унтраах хэрэгслэлийг байруудад байрлуулна.<br>Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж ажиллана. | Харьяа байруудад тавигдсан галын хорны даралтыг сар бүр үзэж шалган, 100 хувь цэнэглэж, шинээр 30 ширхэг галын хорыг суурилуулан, 120 ширхэг галын хорыг цэнэглэж, галын шланк (20 метртэй) 50 ширхэг, галын элстэй сав 4 ширхэг, галын нөмрөг 6 ширхэг, зөөлөн холбоо (авто чиргүүл 4тн даацтай) 4 ширхэгийг тус тус суурилуулан ажиллав.<br>Галын анхан шатны багаж хэрэгсэлд үзлэг хийн галын сарын комыг шаардлагатай газарт нь 2 ширхэгийг байрлуулав. Жил бүрийн бүх нийтийн бэлэн байдлыг хангах, гамшгийн үеийн дуут дохиогоор ажиллах дадлага сургуульлалт 2023 оны 06 дугаар сарын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамтран зохион байгуулдаг. | | 08-ны өдрийн 16:00 цаг болох үеэр харьяа байруудад байрлаж байгаа байгууллагуудыг хамруулан ажилласан. Мөн Төрийн ордны онцгой байдлын алба, Зам, тээврийн хөгжлийн яам, Соёлын яамтай хамтран тус яамны болон байгууллагын нийт ажилтан, албан хаагчдыг хамруулсан гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх тактикын сургалтыг зохион байгуулан ажиллав.<br>Харьяа байруудын галын дохиоллын мэдээллийн системд ээлжит сервес үйлчилгээг хийж ажилласан. | |
| 1.8 | Цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг тогтмол хангаж ажиллана. | 1,103.3 сая төгрөг | Цахилгааны үр ашигтай, найдвартай ажиллагааг жил бүр сайжруулан ажилласан байх. | Харьяа байруудын цахилгааны далд монтажийн 70.0 хувь нь ашиглалтын шаардлага хангахгүйгээс галын аюултай байдлын түвшинд байна. Мөн цахилгааны утас болон өрөө тасалгааны гэрэлтүүлэх хэрэгсэл хуучирч, элэгдэж муудсан.<br>Иймд тогтмол хугацаанд засвар үйлчилгээний ажил хийдэг. | Цахилгаан хангамжийн тоноглолын ашиглалтын хэвийн ажиллагааг хангаж ажилласнаар үйлчлүүлэгчид жилийн турш цахилгаан хангамжаар найдвартай хангагдан ажилласан байх. | Засгийн газрын II байрын "А" корпусын цахилгааны ерөнхий оролтын самбарын хуучин тоолуурыг модемтэй шинэ тоолуураар шинэчилсэн. Мөн тус байрны "Д" корпус (Сангийн яам)-ын өргөтгөл болон серверийн өрөөний цахилгааны ерөнхий оролтын самбарын тоолуурт модем суурилуулав.<br>Засгийн газрын III байрын ерөнхий тэжээлийн кабель шугам гэмтсэнийг өндөр хүчдэлийн лабораториар гэмтлийн цэгийг тодорхойлуулж, муфтлан засварлаж хэвийн болгосон.<br>Засгийн газрын III байрын цахилгаан эрчим хүчээр хангах ХТП-834 0,4 кВТ-ын хувиарлах байгууламжинд 630 амперын рубелник сольж шинэчлэв.<br>Засгийн газрын VIII байрын ерөнхий тэжээлийн кабель шугам гэмтсэнийг өндөр хүчдэлийн лабораториар гэмтлийн цэгийг тодорхойлуулж, муфтлан засварлаж хэвийн болгосон.<br>Засгийн газрын XI байр (СЕХ)-ын II давхрын хүчний хувиарлах самбарын 2 комыг шинээр сольсон.<br>Засгийн газрын XIII байрыг цахилгаан эрчим хүчээр хангадаг хаалттай дэд өртөө ХТП-834-ийн 0,4 кВт-ийн хуваарилах байгууламжийн толгой автомат шатсаныг 630А-ийн шоо рубилник тавьж шинэчилсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн харьяа байруудын цахилгааны байгууламжид үзлэг шалгалт, засвар үйлчилгээг тогтмол хийж ашиглалтыг сайжруулан ажилласан. | |
| 1.9 | Ус, дулаан хангамжийн найдвартай ажиллагааг тогтмол хангаж ажиллана. | 516,0 сая төгрөг | Ус, дулааны шугам сүлжээний тоноглолд засвар үйлчилгээний ажил хийж, өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангасан байх. | Ус, дулааны шугам хоолой, насос, бойлер зэрэг хэрэгслүүд моралын элэгдэлд орсноос шалтгаалан шинэчлэх шаардлагыг эрх бүхий байгууллагаас тавьдаг. | Харьяа байруудын үзельд , элэгдэж муудсан халуун усны ялтсан бойлер, халуун усны автомат, халаалтын нөөц насос зэргийг суурилуулан, өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангаж ажилласан байх. | Засгийн газрын II байр (ХНХЯ, УУХҮЯ)-ын албан өрөөнүүдийн ф15 пвс паянлан паар болон I давхрын ариун цэврийн өрөөний цоорсон бохирын шугамнуудыг шинээр солив. Мөн тус байр (Сангийн яам)-ын халаалтын шугамны колекторын хаалтны толгойнууд бариxгүй болсоныг шинэчлэв.<br>Засгийн газрын II байр (Сангийн яам)-ын бохирын төв шугамыг шинээр сольж, "А"-үзельд байрлах халаалтын шугам цоорч гэмтсэнийг гагнаж хэвийн болгов.<br>Засгийн газрын III байрын үзельд байрлах тосон монометр, халаалтын насосны холхивч болон I-IV давхрын албан өрөө тасалгааны халаалтын шугамны ф15 хаалт, ф15 хий авагчийг тус тус шинээр сольж суурилуулсан.<br>Засгийн газрын IV байрын цэвэр болон халуун усны төв магистрал шугам элэгдэж, цоорсон тул шинээр ППР наадаг шугамаар солив. Мөн тус байрын шатны хэсэгт байрлах халаах шугам, албан өрөөнүүдийн ф15 хаалт, ф15 хий авагч болон хуучин пааруудыг шинэчилсэн.<br>Засгийн газрын VIII байрын үзельд байрлах цэвэр усны шугам, албан өрөөнүүдийн ф15 хаалт, ф15 хий авагч элэгдэж, өндөр эрсдэлтэй болсон тул шинээр сольж, сайжруулав.<br>Засгийн газрын IX байрын халаалтын шугамны ф25 коллектор, цайны газрын бохирын гадна болон дотор худгийг засаж сайжруулав. Мөн халаалтын ф219 шугам цоорсоныг гагнаж, засвар үйлчилгээг хийж, дулааны үзельд байрлах халуун усны хуучин автомат хаалтыг комоор нь солив.<br>Засгийн газрын XI байрын халаалтын ф15 колекторын хаалт, цэвэр усны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ф100-ын төв хаалтууд муудсаныг шинэчилсэн.<br>Засгийн газрын XII байрын дулааны үзелийн хэрэглээний халуун усны автомат хаалт ком, баруун жигүүрийн үзельд байрлах халуун усны насосыг тус тус шинээр сольсон.<br>Засгийн газрын XIII байрын үзельд шинээр халаалтын тоолуур, насос, цэвэр болон халуун усны төв магистрал шугамыг ф89 шугамаар шинээр сольж сайжруулав.<br>Улмаар сантехникийн шугамны бэлэн байдлыг хангах болон ус, дулаан хангамжийн баталгаат байдлыг хангах чиглэлээр засвар үйлчилгээний ажлыг тогтмол хугацаанд хийж ажилласнаар инженерийн байгууламжийн найдвартай байдал нэмэгдсэн. | |
| 1.10 | Барилга, засвар мужааны үйлчилгээг хийж гүйцэтгэх | 199,4 сая төгрөг | Байгууллагаас тавьсан хүсэлт болон ерөнхий хэрэгцээ шаардлагад үндэслэн барилгын засварын ажил хийх | Өрөө тасалгааны өнгө үзэмжийг жил бүр засаж сайжруулан засвар үйлчилгээг хийдэг | Элэгдэж муудсан дээвэр, ариун цэврийн болон албан өрөө, тасалгаа зэрэг нийтдээ 20-оос доошгүй өрөө, талбайд засвар тохижилтын ажил хийнэ. | Байгууллагуудаас ирсэн хүсэлт, албан бичигт үндэслэн нийт 110 гаруй албан өрөөнд урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1. Засгийн газрын II байр буюу "А" корпусын (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам) 207, 310-316 тоот өрөөнүүд, "Б" корпусын 104, 203-213, 215 тоот өрөөнүүд болон II давхрын нийтийн эзэмшлийн талбайн бүрэн засвар, "В" корпусын 411 тоот (ТНБД) өрөөний явган ханыг модон дүбэн материалаар солих, "Г" корпусын 205, 206 тоот өрөө, III давхрын бүх албан өрөө (301-317), нийтийн эзэмшлийн талбайн хана, таазны засвар, IV давхрын 403-410 тоот өрөө, "Е" корпусын 902 тоот өрөөнүүдийг засварлаж шинэчлэв. Мөн "Е" хэсэгт өөрчлөлтийн бэлтгэл ажлын хүрээнд 1-11 дүгээр давхрын бүх өрөөнд вакум цонхны бариул, цоожны гажилт, резин жийргэвчийг сольж, тохиргоог хийж, гадна пасадны зарим чулуу цуурч, хагарч унасаныг хэсэгчлэн засварлав.<br>2. Засгийн газрын III байрын 501, 508, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 211 тоот өрөөг засварлаж тохижуулан хүлээлгэн өгөв. 107 тоот өрөөнд паркет шал, 314 тоот өрөөний ханын обойг тус тус шинээр солив.<br>3. Засгийн газрын IV байр (Үндэсний аудитын газар)-ын шилэн ханыг сольж, 109, 303, 308 тоот өрөөнүүдийг сэргээн засварласан. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 1-4 давхрын нийт 127 ширхэг цонхны сийгэлтийг арилгах хүрээнд резин жийргэвч, нугас, цоож, бариулыг сольж, гажилтыг засварлаж, тохиргоог хийж гүйцэтгэсэн.<br>4. Засгийн газрын VIII байрын 401 тоот өрөөг засварлаж тохижуулан хүлээлгэн өгсөн.<br>5. Засгийн газрын IX байрын "Б" корпус 213 тоот өрөөг засварлаж тохижуулан, тус барилгын дээврээс борооны ус нэвчин орж, дусаал дусаж байсныг хэсэгчилэн засварлаж хэвийн болгосон. Мөн I давхарт байрлах МХЕГ-ын баруун жигүүрийн коридорын шалны хүрээ, далдлагч, зарим өрөөний хаалгыг сольж хэсэгчилэн засварлав.<br>6. Засгийн газрын XI байрын Алтанбулаг чөлөөт бүсийн 1007, 1101а, 1101б, 1101в тоот өрөөнүүдийн хана, таазны өнгийг сэргээн засварлав. Мөн 4 ширхэг хуучирч муудсан вакум цонхыг 3 давхар шилтэй вакум цонхоор сольж, 213-218 тоот өрөөнүүдийг засварлаж хүлээлгэн өгөв.<br>7. Засгийн газрын XII байрын үүдний саравч элэгдэлд орж төмөр нь зэвэрч муудсан тул борооны ус зайлуулах хэсэгт залгаасгүй урт гөлмөн төмөр дэвсээд түүн дээр зэврэлтээс хамгаалж эдэлгээг уртасгах зорилгоор чулуутай хар цаас наах засварлав. Тус байрын 102, 121, 408 тоот өрөө болон I давхрын ариун цэврийн өрөөг засварлаж хүлээлгэн өгөв. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 102, 121, 408, 112, 119 тоот өрөө, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэгдүгээр давхрын ариун цэврийн өрөө, архивын өрөө, II давхрын хурлын танхим, коридор зэргийг засварлаж тохижуулав.<br>Мөн III давхрын ариун цэврийн өрөө, IV давхрын ариун цэврийн өрөө, 103а, 103б,105, 106, 217а, 217б, 219, 226, 223а, 223б, 224, 225, 201а, 201б, 201в, 303, 332, 401, 403, 421, 422б, 423, 434, 436 тоот өрөөнүүдийг засаж сайжруулав.<br>Барилга, хот байгуулалтын яамны сайдын өрөө (322 тоот өрөө)-г бүрэн засварлаж тохижуулан хүлээлгэж өгсөн.<br>Үүний зэрэгцээ Ашигт малтмал, газрын тосны газрын 216 тоот өрөөг засварлав.<br>Хүний эрхийн үндэсний комиссын 7 өрөөний хуучирч муудсан 11 модон цонхыг 3 давхар шилтэй 11 ширхэг вакум цонхоор сольж шинэчилсэн.<br>Мөн тус байрын I давхрын ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан иж бүрэн тохижуулж засварлав.<br>8. Засгийн газрын XIII байр (Зам, тээвэр хөгжлийн яам)-ын үүдний саравч өнгө үзэмжээ алдсан, шатны чулуу нь моралын элэгдэлд орсоны улмаас ховхорч унасанг сэргээн засварлаж тохижуулав.<br>Тус барилгын дээвэр нь элэгдэл, эвдрэлд орсоны улмаас парпедны шавар болон чулуутай хар цаас нь хагарч цууран дотогш бороны ус нэвчин орж, дусаал дусаж байсныг хэсэгчилэн засварлах тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэв. Мөн 102, 104, 107, 205 тоот өрөөнүүдийг засварлав.<br>Барилгын өргөтгөлийн (хуучнаар Авто тээврийн үндэсний төв) II давхрын 201, 202 тоот өрөөнүүдийг бүрэн засварлаж тохижуулан хүлээлгэн өгөв.<br>Мөн 102, 103, 110, 205 тоот өрөөнүүдийн хуучирч муудсан 6 цонхыг 3 давхар шилтэй хуванцар вакум цонхоор сольж шинэчилсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Барилгын насжилтыг уртасгах зорилгоор II, XII байрнуудын суурийг хамгаалж борооны ус орохоос сэргийлэх ажлыг хийж гүйцэтгэв. | |
| 1.11 | Лифт болон агаар сэлгэх хэрэгслэлийн аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллана. | 43,2 сая төгрөг | "Лифт, агаар сэлгэлтийн хэрэгслэлийг аюулгүй ашиглах дүрэм"-ийг баримтлан осол аваргүй ажилласан байх. | Лифтэнд сар бүр мэргэжлийн байгууллагаар үзлэг шалгалт хийлгэж гарсан зөрчил дутагдлыг засаж ажилладаг. | Мэргэжлийн эрх бүхий байгууллагаас баталсан дүрмийг мөрдөн ажилласнаар аюул, осол гаргахаас урьдчилан сэргийлж ажилласан байх. | Засгийн газрын II, III, IX "А", XI байрын хүн зөөврийн лифтний хонгилын хаалга, кабин, хүдэгт гоожсон тос, реленүүдийн бохирдлыг арилгаж, редукторын тосыг сольсон.<br>Засгийн газрын II байрын "Д" корпуст 4, "Е" корпуст 1, III байранд 1, IX байрын "А" корпуст 1, XI байранд 3 ширхэг лифтнүүдийг тус тус магадлалд оруулсан.<br>Засгийн газрын II байрын "Д" корпусын хүн зөөврийн лифтний хос контактор шатсаныг сольж шинэчилсэн.<br>Засгийн газрын III байрын хүн зөөврийн лифтний хөдөлгүүрийн удирдлагын инвертер, контактор, толгой автомат шатсаныг шинэчилж хэвийн болгосон.<br>Лифт ашиглалтын цаг үеийн үзлэг оношлогоог тухай бүр хийж, хяналт тавин ажиллав.<br>Тухайлбал лифтэнд нийт 18, агааржуулалтын чиглэлээр 9 дуудлага тус тус ирүүлснээс тухай бүрт нь алдаа, гэмтэл саатлыг түргэн шуурхай арилган ажиллаж, харьяа байруудад агааржуулалтыг хийж, сэлбэн засаж, хяналт тавин ажиллав. | 100% |
| 2. | **"Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтыг хангах"** зорилтын хүрээнд: | 192,6 сая төгрөг | Ажилтан, албан хаагчдыг ажлын байран дээр суралцах, хөгжих боломж, хамгаалах нөхцөлөөр хангах | Хүний нөөцийн бүрдэлт, сургалт, хөгжүүлэлтийг тогтмол хийж ажилладаг. | Чадварлаг, тогтвор суурьшилтай ажиллах боловсон хүчинг хөгжүүлж, хүний нөөцийн манлайллыг хөгжүүлж ажиллана. | Байгууллагын эрхэм зорилго, зорилтыг биелүүлэх чадвартай хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хийх хүрээнд албан хаагчдыг сонгон шалгаруулж ажилд авах, ажлын байранд сургаж дадлагажуулах, ажиллах нөхцөл, боломжийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлэх, хариуцлага тооцох ажлыг цогцоор нь хийж ажиллав. | 100% |
| 2.1 | Хөдөлмөрийн эрүүл, аюулгүй байдлыг хангаж ажиллах | 111,4 сая төгрөг | Хөдөлмөрийн аюул ослогүй ажиллах. | Ажлын байран дээр хөдөлмөрийн аюулгүй байдлын осол бүртгэгдээгүй. | Хүний эрүүл мэндэд хамгийн бага сөрөг нөлөөтэй бараа материал, багаж | Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын "Лабораторын шинжилгээний дүгнэлт" болон Стандарт, хэмжил зүйн газраас баталгаажуулдаг "Үл тохирлын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгслэл ашиглан, сургалт хөгжүүлэлтийг тогтмол хийж ажиллах. | гэрчилгээ"-гээр баталгаажсан хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, чанарын шаардлага хангасан бараа материал, багаж хэрэгслэлийг худалдан авч, тасралтгүй ханган ажиллаж байна. Мөн харьяа байруудын нийт ажилчдад ажлын байран дээр нь хөдөлмөрийн аюулгүй байдлын зөвлөгөө мэдээлэл, сургалтыг Хууль, эрх зүй гэрээ хариуцсан мэргэжилтэн, Хөдөлмөр хамгааллын инженерээр өгүүлж ажиллав.<br>ХАБЭА-н менежментийн тогтолцоог нэвтрүүлэхтэй холбоотой, хууль эрх зүйн болон бусад шаардлагын талаар мэдлэг олгоход чиглэсэн сургалтыг MNS 4969:2000 стандартын дагуу "Оломт амжилтын түлхүүр" сургалтын төвтэй хамтран зохион байгуулав.<br>Улмаар Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээ болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг шинээр боловсруулан ажиллав.<br>Үйлчилгээний ажилчдын ажлын ачааллыг хөнгөвчлөх, эрүүл аюулгүй байдлыг хангах, шинэ дэвшилтэт багаж хэрэгслэлийг сонгож улмаар "Wurth" брэндийн тоос сорогч 30, индүү 6, уурын индүү 2, хивс угаагч 16, сэгсэрч хувин 70, шал угаагч 7, өвс хадагч 2, угаалгын машин 8 ширхэгийг тус тус худалдан авч, шаардлагатайг нь албан хэрэгцээнд ашиглаж эхлэв. | |
| 2.2 | Хүний нөөцийн бүрдэлт, сургалт хөгжүүлэлт, шагнал урамшууллыг хийж ажиллах | 75,2 сая төгрөг | Хүний нөөцийн бүрдэлтийг тогтмол хийж, сургаж, хөгжүүлэх, тусалж дэмжих | Хүний нөөцийн бүрдэлтийг тогтмол хийж, сургаж тусламж дэмжлэг үзүүлдэг. | Хүний нөөцийн бүрдэлтийг ил тод, нээлттэй хийж, ажлын байран дээр сургаж, тусламж дэмжлэг үзүүлсэн байх. | Байгууллагын вэб сайт, Хөдөлмөрийн бирж, СХД, БЗД, СБД, ЧД-тэй хамтран хүний нөөцийн бүрдэлтийг хийж ажиллав. Шинээр ажилд орж буй ажилтанг гурав хүртэлх сараар туршилтаар ажиллуулах хугацаанд нь практикийн сургалт мэдээлэлд хамруулж, зөвлөгөө өгч ажилласны үндсэн дээр 45 ажилтанг Захирлын зөвлөлийн хурлаар цаашид ажиллуулах эсэхийг шийдвэрлэн ажиллав. Ажилчдын санал хүсэлтийг хүлээн авч холбогдох | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүрэм, журмын хүрээнд өндөр насны тэтгэвэрт гарсан 12 ажилтанд нийлбэр дүнгээр 48,9 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлэв. | |
| 2.3 | Дотоод аудит, хяналт шинжилгээ, хууль, эрх зүй, чанар стандартыг хангах үйлчилгээ | 6,0 сая төгрөг | Байгууллагын үйл ажиллагаа хууль, стандартын хүрээнд явагдаж, хяналт шинжилгээ хийгдэж байх. | Жил бүр Стандарт, хэмжил зүйн газрын шалгалтанд хамрагдаж, гадна болон доторх аудитын шалгалт хийгддэг. | Байгууллагын үйл ажиллагааг хууль тогтоомж, стандартын дагуу явуулж ажилласан байх | Нийтээр дагаж мөрдөгдөх хууль тогтоомж болон байгууллагын дүрэм журмыг баримтлан ажиллах явцад тогтмол хяналт тавин ажиллав.<br>Шаардлагатай тохиолдолд төр засгийн гаргасан хууль тогтоомжид үндэслэн байгууллагын дотор мөрдөгдөх дүрэм журмыг шинэчлэх, жишиг байдлаар хэрэгжүүлэх ажлыг цаг алдалгүй хийн ажиллав.<br>Мөн байгууллагын дотоод хяналт шалгалтаар бараа материалын анхан шатны баримтын бүрдэлтэнд хийсэн хяналтын ажил, сар бүр олгодог нормын бараа материалын зарцуулалтанд хийсэн хяналт шалгалтын ажил, харьяа байруудын цэвэрлэгээ үйлчилгээний хяналт шалгалтын ажил, нэмэгдэл цалин хөлс бодолтонд хийсэн хяналт шинжилгээний ажлуудыг тус тус хийж гүйцэтгэв. Улмаар байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын ажлын хүрээнд үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилт болон тушаал, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт шалгалтын ажлыг үргэлж хийж гүйцэтгэсэн. | 100% |
| 3 | "Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх" зорилтын хүрээнд: | — сая төгрөг | Туршлага судалж, шинэ арга барил, технологийг нэвтрүүлэх | 2022 онд ХБНГерман Улсын барилга байгууламжийн засвар үйлчилгээний үйл ажиллагааг интернэтээс судалж, туршлага судлан ажилласан. | Нийтлэг үйлчилгээний ажлын талаарх давуу болон сул тал, ашиглагдаж буй бүтээгдэхүүний нэр төрөл, арга туршлагыг харилцан солилцон ажилласан байх; | Ижил тестэй үйл үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд (ТЗҮЭГ, ННҮГазар болон хувийн хэвшил)-тэй харилцан уулзалт зохион байгуулан, туршлага судлан ажилласан. Улмаар байгууллагын үндсэн үйл ажиллагаанд тохиромжтой шинэ, чанартай ажлын багаж хэрэгсэл (тоос сорогч, шалны хувин, зүлэг хадагч г.м), үйлчилгээний нэр төрөл (автомашины зогсоолын зохицуулалт), арга барил (2-3 үйлчлэгч багаар хамтарч албан өрөөг цэвэрлэх), цар хүрээ (БОАЖЯ)-г өргөжүүлэн ажиллав. | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1 | Төрийн байгууллагад үзүүлдэг нийтлэг үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор гадаад улсын болон дотоодын ижил төстэй байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, туршлага судлах, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах; | —— сая төгрөг | Дотоодын нэгээс доошгүй байгууллагатай хамтран ажиллаж, харилцан туршлага солилцон ажилласан байх; Гадаадын ижил төстэй байгууллагын үйл ажиллагаар судалж ажиллах; | Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар, орон нутгийн ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагаас туршлага судалж, харилцан үр ашигтай хамтран ажилладаг. | Дотоодын нэгээс доошгүй байгууллагатай шинээр харилцаа холбоо тогтоож, харилцан үр ашигтай хамтран ажилласан байх. Гадаад улсын ижил төстэй нэгээс доошгүй байгууллагын үйл ажиллагаар судлан, мэдээллийн бааз үүсгэх | Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай ижил үйл ажиллагаа явуулдаг дотоодын байгууллагууд (Uniservice, Рийч пойнт ХХК)-ын туршлагыг судлан ажиллав. Мөн засвар үйлчилгээ, аюулгүй байдал, ногоон байгууламж, барилгын үйлчилгээ болон бусад чиглэлээр судалж мэдээллийн бааз үүсгэн ажиллалаа. | 80% |
| 4 | **“Санхүү, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалтыг удирдан ажиллах”** зорилтын хүрээнд: | 6,8 тэрбум төгрөг | Орлогоороо санхүүжиж, үйл ажиллагаагаа хэвийн явуулсан байх. | Өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажилладаг. | Хөрөнгө санхүүгийн хувьд үйл ажиллагаа хэвийн санхүүжүүлж ажилласан байх. | Үйлдвэрийн газар нь явуулсан үйл ажиллагааныхаа үр дүнгээр өөрөө өөрийгөө бүрэн санхүүжүүлэн ажиллав. 2023 онд төвлөрүүлэх орлогыг тайлант хугацаанд 100,0 гаруй сая төгрөгөөр өсгөн төвлөрүүлж ажиллав. | 100% |
| 4.1 | Төсөв төлөвлөгөөт хөрөнгийг хэмжээнд төвлөрүүлж, үр ашигтай зарцуулж ажиллана. | 6,8 тэрбум төгрөг | Өмнөх оны мөн үед олох төлөвлөгөөт орлогоос тухайн оны мөн үед олох орлогыг бууруулахгүй ажиллах; | 2022 онд нийт 6,4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн. | Орлогыг нэмэгдүүлж, зарцуулалтын үр ашигтай хийсэн байх. | Орлогыг өмнөх оны мөн үеэс 418,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, зардлын 6,700.0 сая төгрөгийг захиран зарцуулж, боломжит хэмжээний хуримтлал нэмж үүсгэн ажиллав. | 100% |
| 4.2 | Өмч хөрөнгийн менежментийг сайжруулан ажиллах | — | Өмчийн бүртгэл тооллого, ашиглалтыг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байх | Эрх бүхий байгууллагаас 2020 онд өмчийн менежментийг үлгэр жишээ явуулсан гэж үнэлсэн | Төрийн өмч хөрөнгийн бүртгэл, тооллого хийж, ашиглалтыг сайжруулан, эд хөрөнгийн ямар нэг зөрчилгүй ажилласан байх. | Тайлант хугацаанд байгууллагын эд хөрөнгийн үзлэг, тооллогыг хийж гүйцэтгэн, тайлан мэдээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллав. Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгдэх чанар, загвар, шаардлагад нийцсэн эд хөрөнгийг бүртгэн, сэлбэн засаж сайжруулан, үргүй зардал гаргахгүй байх талаар анхаарч ажиллав. Улмаар бараа материал, сэлбэг хэрэгслэлийн хадгалалт, хамгаалалт, тэрэмжүүлэлт, цэгцлэлтийг боловсронгуй болгож, бэлэн байдлыг хангаж ажиллалаа. ТӨБЗГазраас төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэхэд биелэлт 95%-тай буюу | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "хангалттай" гэж үнэлсэн. | |
| 4.3 | Харьяа байруудад байрлах төрийн байгууллагуудын байр ашиглалт, нийтлэг үйлчилгээний чиглэлээр улсын төсөвт тусгуулан батлуулах санхүүжилт, хөрөнгө оруулалтын ажлын тооцоо судалгааны төсвийн саналыг боловсруулж, тухайн байгууллагуудад хүргүүлэн ажиллах; | --- | Харилцагч байгууллагуудтай хамтран ажиллах болон хөрөнгө оруулалтад шаардагдах хөрөнгийн талаар мэдээлэл хүргүүлж хамтран ажилласан эсэх | Харьяа байруудад байрлаж үйл ажиллагаа явуулж буй 81 /Ажил, нийтлэг үйлчилгээ гүйцэтгэх-36, түрээс-12, граж-12, бусад-21/ байгууллагатай гэрээ байгуулсан. | Харьяа байруудад байрлан ажилладаг төрийн байгууллагуудад байр ашиглалт, нийтлэг үйлчилгээний ажлын чиглэлээр ирэх жилийн төсөвт ямар хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын ажил тусгуулах шаардлагатай тухай саналыг хүргүүлж ирэх онд хэрхэн хамтран ажиллах талаар хэлэлцсэн байх. | Засгийн газрын байранд байрлаж үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын эзэмшиж байгаа байр, талбай, эд байгаа нийтлэг үйлчилгээний хэмжээнд ногдох зардлыг тухайн байгууллагын төсөвт суулган санхүүжүүлж байхаар заасны дагуу 2024 оны улсын төсөвт тусгуулах шаардлагатай байр ашиглалтын зардлын саналыг харилцагч байгууллагуудад 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 99-128 дугаар тоот албан бичгээр хүргүүлж ажилласан. Мөн 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 167-196 дугаар тоот албан бичгээр дахин хүргүүлсэн. | 100% |

------ x ------

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний Хавсралт №2-ийн биелэлт.

## "Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн биелэлт

| Хэрэгжүүлэх хөтөлбөрийн төрөл | Агуулга | Хэрэгжүүлэх үндэслэл | Төрөл |
|---|---|---|---|
| 1. Ажилтан, ажиллагчдыг ажиллах нөхцөлөөр хангах | 1.1. Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангах | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйл, Байгууллагын хөдөлмөрийн Дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь заалт; | Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор албаны компьютерүүдэд вирусын эсрэг программын лицензийг сунган ажиллав.<br>Албаны чиг үүргийг гүйцэтгүүлэх хүрээнд тоос сорогч 30, индүү 6, уурын индүү 2, хивс угаагч 16, сэгсэрч хувин 70, шал угаагч 7, өвс хадах багаж 2, угаалгын машин 8 ширхэгийг тус тус худалдан авч, албан хэрэгцээнд ашиглаж эхлэв. |
| 2. Нийгмийн баталгааг хангах | 2.1. Хоол, унааны хөнгөлөлт үзүүлнэ. | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт,<br>Байгууллагын хөдөлмөрийн Дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт; | Тус оны 1 дүгээр сараас эхлэн албан хаагчдад ажлын нэг өдөрт олгох хоол унааны нэмэгдлийг 2,000 төгрөгөөр нэмэгдүүлж ажиллав.<br>Нэг ажилтны хоол, унааны хөнгөлөлтөнд зориулж ажлын нэг өдөрт 8,000 төгрөг олгоход 255 ажилтан, албан хаагчид хамрагдаж нийт 372,3 сая төгрөг зарцуулсан. |
| | 2.2. Орон байраар хангах, амьдрах нөхцөлийг нь сайжруулах | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт,<br>Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.3.4 дэх заалт; | Засгийн газрын шийдвэрээр Эдийн засаг, хөгжлийн яам Засгийн газрын XI байранд байрлах болсноор тус байранд барилгын дотор засварын ажлыг хийснээр тухайн байранд дахин ашиглахад тохиромжгүй болсон зарим эд зүйлсийг албан хаагчдад олгож ажиллав. Үүнд: Өмч хамгаалах, үнэ тогтоох комиссын шийдвэрээр паркетан шал 20, вакум цонх 9, хаалга 10, суултуур 6, угаалтуур 5 албан хаагчдад тус тус өгч ажиллав. |
| | 2.3. Сургалтын төлбөр олгох | Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.7 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт; | Төсөвчин бэлтгэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг мөрдөн ажиллах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах эрх олгох зэрэг сургалтанд албан хаагчдыг хамруулснаар байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулах боломж нөхцөл бүрдэн ажиллав. |
| 3. Нэмэгдэл баталгаа | 3.1. Ажил албан тушаалыг хэвээр хадгалах. | Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйл; | Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлд заасан ажил албан тушаалыг хэвээр хадгалах тухай заалтыг чанд мөрдөн ажиллаж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | 3.2. Ажилтан, албан хаагчдад үзүүлэх хөнгөлөлт | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалт | |
| 4. Цалин хөлс | 4.1. Албан тушаалын цалин, мэргэшлийн зэрэг цол, ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал олгох | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт,<br>Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалт | Ажилтан, албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг ажил үүргээ чанартай гүйцэтгэдэг шалгуурыг харгалзан 90 ажилтанд 74,6 сая төгрөг олгов. Илүү цагийн нэмэгдэл хөлсийг давхардсан тоогоор 233 ажилтанд олгоход 26,3 сая төгрөг зарцуулав.<br>Мөн ажилласан хугацаагаар цалингийн шатлал ахисан 16 ажилтан, байгууллагын ажилласан жилийг тооцож цалингийн нэмэгдэл олгох журмын шаардлагыг бүрэн хангасан 86 ажилтанд нэмэгдэл цалинг олгож ажиллав. Хавсран ажил гүйцэтгэсэн ажилчдад 60 хүртэлх хувиар тооцож олгоход 265,6 сая төгрөг зарцуулав.<br>Эхний хагас жилд 227 ажилтанд үр дүнгийн урамшууллыг олгоход 31,2 сая төгрөг зарцуулав. |
| 5. Ахмадын дэмжлэг | 5.1. Тэтгэвэр тогтоолгох | Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1, 82.5, дэх хэсэг, Байгууллагын хөдөлмөрийн Дотоод журмын 9 дүгээр зүлийн 9.3.10 дахь заалт | 2023 оны жилийн эцсийн байдлаар өндөр насны тэтгэвэрт гарсан 12 ажилтанд 6 сарын дундаж цалин хөлстэй нь тэнцэх хэмжээний тусламж олгоход зориулж 48,9 сая төгрөг зарцуулав. |
| | 5.2. Тус байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмад настанд тусламж олгох | Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль 8.5 дахь хэсэг, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам 9 дүгээр зүйлийн 9.3.6 дахь заалт; | Монгол Улсын төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 2 ахмад настанг шагнав. Мөн сар шинийн баяр (Билгийн тооллын хаврын эхэн сарын шинийн нэгэн)-ыг тохиолдуулан 100 ахмад настанд нийт 9,1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. |
| 6. Тэтгэмж, тусламж | 6.1. Албан хаагчийн гэр бүлд гачигдал тохиолдвол тусламж олгох | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь зааль; | Ар гэрт нь гачигдал гарсан 30 ажилтанд нийлбэр дүнгээр 8,4 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлсэн. |
| 7. Шагнал урамшил | 7.1. Мөнгөн шагнал олгох | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт,<br>Байгууллагын хөдөлмөрийн Дотоод журам 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт; | --- |

| | | | |
|---|---|---|---|
| | 7.2.Төрийн дээд байгууллага болон Засгийн газрын шагналд тодорхойлох | Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид шагнал урамшуулал олгох журам" | Байгууллагад үр бүтээлтэй, өндөр амжилт гаргасан ажилчдад төрийн дээд шагнал "Алтангадас" одонг 3, Хөдөлмөрийн хүндэт медалиар 17, салбарын хүндэт тэмдгээр 4 ажилтан тус тус шагнагдсан. |
| 8. Эрүүл мэнд | 8.1. Эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамрагдах, үйлчилгээ авах | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйл | Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн оношлогоо шинжилгээнд албан хаагчдыг хамруулах ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 10-21-ний өдөр зохион байгуулав. Мөн байгууллагын болон харьяа байруудад байрлан үйл ажиллагаа явуулдаг албан байгууллага, аж ахуй нэгжүүдийн нийт ажилтан, албан хаагчдыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газрын II, III байруудад эмнэлгийн анхан шатны үзлэг буюу яаралтай тусламж үйлчилгээг үзүүлж ажиллав. |

----- x -----

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний Хавсралт №1-ийн биелэлт.

Заслийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын ажилчдын дунд 2023 онд хийгдэх сургалтын төлөвлөгөөний биелэлт

| № | Сургалтын нэр | Сургалтын зорилго | Хугацаа | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| | **Нэг. Ажлын байран дахь сургалт** | | | |
| 1. | Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын хандлага. | Нийт ажилтан, албан хаагчдад мэдлэг, мэдээлэл олгох | I улирал | Хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий тойм; Хөдөлмөр эрхлалтийг дэмжих зорилго, зорилт; Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн өнөөгийн байдал сэдэвт хоёр цагийн сургалтыг захиргааны албан хаагчдад 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хийв.<br>Үүний үр дүнд хөдөлмөрийн зах зээл дээрх ажиллах хүчний нийлүүлэлт болон цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаарх мэдлэг мэдээлэл сайжирч, төлөвлөлтөнд анхаарч ажиллах үндэс бүрэлдсэн. |
| 2. | Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журам болон бусад журмыг танилцуулах | Нийт ажилтан, албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх | I улирал | Хууль эрх зүй, гэрээ хариуцсан мэргэжилтэн, хүний нөөцийн мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэй баг 2023 оны I улиралд харьяа байр тус бүр дээр очиж Хөдөлмөрийн тухай хууль болон Дотоод журам, бусад журмын талаарх сургалт, мэдээллийг өгч ажилласан. |
| | **Хоёр. Мэргэшүүлэх, дадал эзэмшүүлэх сургалт** | | | |
| 1. | Цэцэг, ногоон байгууламжийн үйлчилгээ | Ургамал арчлах арга арчилгаанд суралцах | II, III улирал | Нийт үйлчлэгч болон бусад ажилтнуудад тасалгааны болон мандлын цэцэг арчлах, тарих, бордох, тайралт хийх бө мод хэлбэржүүлэлтийн талаарх зөвлөгөө мэдээллийг байр тус бүр дээр хийж ажиллав. |
| 2. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалт | Хууль тогтоомжийн дагуу ажиллах | Жилдээ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор таван албан хаагчийг сургалтанд хамруулав. |
| 3. | Хөдөлмөр хамгааллын аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай сургалт | Гамшиг осол, галын аюулгүй байдал, хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны талаарх мэдлэг чадварыг дээшлүүлэх | II улирал | ХАБЭА-тай холбоотой зайлшгүй дагаж мөрдөх хууль эрх зүйн болон бусад шаардлагын талаар мэдлэг олгоход чиглэсэн сургалтыг ХАБЭА-н тухай хуулийн 27 дугаар зүйл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/370 дугаар тушаал, MNS 4969:2000 стандартын дагуу "Ололт амжилтын түлхүүр" сургалтын төвтэй хамтран 2023 оны 01 дүгээр сард нийт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | албан хаагчдын дунд зохион байгуулан ажиллав. |
| 4. | Онцгой байдлын газартай хамтран гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалт | Гамшиг осол, галын аюулгүй байдлын талаарх мэдлэг олгох, чадвар дадал суулгах | II улирал | Улс орон даяар нэгэн зэрэг зохион байгуулагддаг "Гамшгийн үеийн дуут дохиогоор ажиллах" тактикийн сургалтанд байгууллагын нийт ажилчид болон харьяа байруудад байрладаг яам, агентлаг, төрийн байгууллагууд, тэдгээрийн албан хаагчдыг хамруулж, зааварзөвлөгөө өгч ажиллав.<br>Төрийн ордны онцгой байдлын алба, Зам, тээврийн хөгжлийн яам, Соёлын яамтай хамтран яамны ажилчид болон байгууллагын зарим ажилтан албан хаагчдыг хамруулсан гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх тактикын сургалтыг Засгийн газрын XIII байранд амжилттай зохион байгуулсан. |
| 5. | Лифтчний аюулгүй ажиллагааны төлөвлөгөөт сургалт | Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах | I улирал | Хүний нөөцийн дутагдлаас хамаарч тогтвор, суурьшилтай ажилтанг сургахаар тус сургалтыг 2024 онд зохион байгуулахаар хойшлуулав. |
| 6. | Мэргэшсэн тесвечний сургалт | Барилгын засвар үйлчилгээний талаар хийгдсэн төсөвт хяналт тавих | I улирал | Барилгын хөгжлийн төвийн төсөвчний анхан шатны сургалтанд 1 ажилтан хамрагдсан. Мөн төсөвчний мэргэшсэн зэрэг сунгах сургалтанд нэг ажилтан суралцаж мэргэшсэн зэргийн хугацааг сунгах боломж хангасан. |
| 7. | Цахилгаанчин, мужаан, сантехникч нарын мэдлэг, ур чадвар дээшлүүлэх сургалт | Албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх | IV улирал | Бүх салбарт нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан ажиллах хүчин буурч, байгууллагын хүний нөөцийн дутагдалтай байгаагаас хамаарч хойшлуулсан. |
| 8. | Хэрэглэт, агаар сэлгэлтийн сургалт | Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах | II улирал | --- |
| 9. | Хүний нөөцийн хөгжлийн сургалт | Албан хаагчдын ур чадвар дээшлүүлэх | Жилдээ | --- |
| 10. | Эрсдэлийн үнэлгээ боловсруулах | Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ боловсруулах | I улирал | Эрсдэлийн үнэлгээ боловсруулах арга зүйн сургалтыг нийт ажилтнуудад 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр "Ололт амжилтын түлхүүр" сургалтын төвтэй хамтран хийж улмаар ажил мэргэжил бүрээр эрсдэлийн үнэлгээ боловсруулан ажиллав. |
| 11. | Мэргэшсэн үйлчлэгчийн сургалтанд хамруулах | Стандарт хэрэгжүүлэх, ажиллагчдад мэргэжил, дадал суулгах | II улирал | Шинэ, залуу боловсон хүчин ажлын байран дээр тогтвортой, удаан ажиллах нь нийгэмд нийтлэг байгаатай холбоотойгоор тухайн сургалтыг тус онд хийхгүй, хойшлуулахаар шийдвэрлэсэн. |
| 12. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын сургалтанд хамрагдах. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог нэвтрүүлж, хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулах | I улирал | ХАБЭА-н тухай мэдлэг олгох MNS 4969:2000 стандартын тухай сургалтыг "Ололт амжилтын түлхүүр" мэргэжлийн сургалтын төвтэй хамтран зохион байгуулан ажилласан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Гурав. Мэргэжил олгох сургалт** | | | | |
| 1. | Мэргэжил дээшлүүлэх сургалт | Албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх | Жилдээ | --- |
| | **Дөрөв. Сургалтанд үзүүлэх бусад дэмжлэг** | | | |
| 1. | Суралцах боломжийг хангах үүднээс ажлын хуваарийг өөрчлөх, чөлөө олгох | Ажилтны нийгмийн баталгааг хангахад туслах | I, III улирал | Их, дээд сургууль, мэргэшүүлэх болон гадаад хэлний сургалтын төвд хамрагдсан ажилтнуудыг тухайн сургалтанд суух цагт нь чөлөө олгон улмаар нөхөж ажиллуулах, бусдаар ажлыг нь гүйцэтгүүлэх хэлбэрээр ажиллав. |
| | **Тавь. Туршлага судлуулах** | | | |
| 1. | Шинэ ажилтныг дадлагажуулах буюу чиглүүлэх сургалтууд | Ажлын байранд дадлагажуулах, арга барил эзэмшүүлэх | Улирал бүр | Чанарын багийн ахлагч, инженерүүд болон холбогдох албан хаагчид шинээр ажилд орсон ажилчдад ажлын байрны тодорхойлолтонд заагдсан чиг үүргээ гүйцэтгэхэд нь чиглүүлэлт хийж ажиллав. |
| 2. | Чанарын багуудын тэргүүн туршлагыг солилцуулах, нэвтрүүлэх | Тэргүүн туршлага нэвтрүүлэх, багийн ажлыг идэвхжүүлэх | IV улирал | Чанарын багууд цахим хуудаснаас бусад байруудын хийж байгаа ажлын мэдээллийг цаг тухай бүрт хүлээн авч туршлага солилцон ажиллаж байна. Цаг үеийн байдалтай хамааралтайгаар Чанарын өдөрлөгийг 2024 оны III улиралд хийхээр хойшлуулав. |

----- x -----